



Япон улсаас Монгол улсад үзүүлж буй тусламж



Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам

Япон Улсаас Монгол Улсад үзүүлж буй тусламж

Япон улс нь хөгжиж буй орнуудад үзүүлэх тусламж (хөгжлийн албан ёсны тусламж) ХАЁТ зэргээр дамжуулан Япон болон олон улсын өмнө цаг үетэй хамт өөрчлөгдөн тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж ирсэн. Япон улсын засгийн газар нь Монгол улсын эдийн засаг болон хүмүүнлэгийн салбарт тусламж үзүүлсэнээр бүс нутаг хийгээд дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг хангахыг зорьж байна.

Хоёр улсын хооронд 1972 онд дипломат харилцаа тогтсон ба 1977 онд Япон улс “Говь улсын үйлдвэр”-ийг (анхаар: 2007 онд хувьчлагдсан) барихад буцалтгүй тусламж үзүүлсэн. 1990 онд ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө социалист тогтолцоотой байсан БНМАУ-д Япон улсаас үзүүлэх тусламж нь Говь улсын үйлдвэрийн техникийн тусламж төдийхнөөр хязгаарлагдаж байв.

1990 оны Монгол дахь нийгмийн тогтолцооны өөрчлөлт нь эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг зэрэг үнэт зүйлсийг бидэнтэй хуваалцах боломжийг нээснээр Япон улс I. Монголын эдийн засгийн хөгжил нь Ази төдийгүй дэлхийн энх тайван, тогтвортой байдалд хувь нэмрээ оруулна, цаашилбал II. Монгол улс Япон улстай найрамдалт түншийн харилцаатай орон болно гэдэгт найдаж Монгол улсад үзүүлэх зээл тусламжийн хүрээгээ өргөжүүлсэн билээ. Үүний зэрэгцээ, олон улсын нийгэмлэгийн хүрээнд “Монгол улсад хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулахыг уриалж, ажил хэрэг болгосон зэрэг Япон улс нь Монгол улсын хандивлагч орнууд дотор голлох үүргийг гүйцэтгэсээр ирсэн.

1990 оноос өнөөг хүртэл Япон улс нь Монгол улсад үзүүлж буй тусламжаараа хандивлагч орнуудыг тэргүүлж ирсэн. Өнгөрсөн хугацаанд Монгол улс нь шилжилтийн хүнд бэрх үеийг даван туулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэс суурийг тавих шатанд нэгэнт орсон. Монголын ард түмэн “зовох цагт нөхрийн чанар танигдана” хэмээх зүйр үгийг иш татан бидний тусламж дэмжлэгт талархаж байгаагаа илэрхийлдэг. Залуу сайн дурын гишүүдээс аваад Японы хөгжлийн албан ёсны тусламжийг хэрэгжүүлэхэд оролцдог олон Япон хүний хичээл зүтгэлийн үр дүнд хоёр орны харилцан итгэлцэл бэхжин улмаар 1997 онд хоёр орны харилцааг “иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд хөгжүүлэхээр тохиролцсон. 2007 оны 2 дугаар сард Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “иж бүрэн түншлэлийн харилцаа”-г шинэ шатанд гарган, цар хүрээг тэлэх зорилгоор “Монгол, Япон улсын хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд одоо энэ хөтөлбөрийн дагуу өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байна.

“Япон Улсаас Монгол Улсад үзүүлж буй хөгжлийн албан ёсны тусламжийн үндсэн чиглэл”

Монгол Улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөр

Монгол улсын өмнө тулгарч буй хөгжлийн өргөн цар хүрээтэй асуудал нь дан ганц Япон улсын тусламж дэмжлэгээр шийдвэрлэгдэхэд хүндрэлтэй байдаг. Тиймээс бидний зүгээс Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан Монгол улсын засгийн газрын хөгжлийн хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд бусад улс орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах бололцоог харгалзан улмаар ХАЁТ-ийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс 2004 оны 11 дүгээр сард Монгол улсад үзүүлэх 5 жилийн тусламжийн хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Япон улс нь “сонгож авах ба голлон анхаарах” байр сууринаас дараах дөрвөн салбарт анхаарч тусламж дэмжлэгээ үзүүлж байна.

Үүнд:

- Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хөхиүлэн дэмжих, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлэх тусламж
- Хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламж
- Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж
- Эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийг буй болгоход үзүүлэх тусламж

Монгол Улсад үзүүлж буй тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой асуудлаар хоёр орны засгийн газар жил бүр эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулан идэвхтэй ажиллаж байна.

Тэргүүлэх салбар дахь хамтын ажиллагааны өнөөгийн байдал

(а) Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хөхиүлэн дэмжих, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлэх тусламж

Монгол Японы төв дэх хамтын ажиллагаа (буцалтгүй тусламж, техникийн хамтын ажиллагаа)

Тус төв нь МУИС-ын харъяа талбайд Япон улсын буцалтгүй тусламжаар баригдсан бөгөөд 2008 оны 12-р сарын байдлаар тус төвд ирсэн хүмүүсийн тоо 900 мянгад хүрчээ. Тус төв нь техникийн хамтын ажиллагааны хүрээнд бизнес болон Япон хэлний курс, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх хөтөлбөр зэргийг явуулж байна. Тухайлбал, бизнесийн курс нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон шинээр үйлдвэрлэл эрхлэх гэж буй иргэдийг хамруулж практикт нийцсэн сургалт явуулж байна. Түүнчлэн тус сургалтыг дүүргэсэн бизнесменүүд өөрсдийн санаачлагаар үйлдвэрлэлийн менежментийг сайжруулах зорилготой “Каизэн (сайжруулалт)” төрийн бус байгууллагыг байгуулсан.



Монгол Японы төв

Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих төсөл (буцалтгүй тусламж)

Хөдөө орон нутгаас хот суурин газарт шилжин ирэх хүн амын тооны өсөлт, ерөнхий боловсролын тогтолцоо 10 жилээс 12 жилд шилжих үйл явцаас үүдэн хот суурин газрын сургуулиуд гурван ээлжээр хичээллэх тохиолдол гарч байгаа нь анги танхимийн хүрэлцээгүй байдлыг харуулж байна. Ерөнхий боловсрол нь зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх чадвартай боловсон хүчнийг бэлтгэх үндэс суурь нь мөн гэж Япон улс үздэг учир ерөнхий боловсролын сургуулийн барилга барих гурван шаттай төсөл хэрэгжүүлсэн ба 2008 оны 3-р сар гэхэд Монгол улсын хэмжээнд нийтдээ 40 сургууль барьсан байгаа. Түүнчлэн 2009 оны 3-р сар гэхэд Улаанбаатар хотод гурван сургууль шинээр баригдах төлөвтэй байна.



Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих төслийн хүрээнд баригдсан сургуулийн барилга (Улаанбаатар хот)

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон байгаль орчныг хамгаалахад зориулан олгосон 2 үе шаттай зээлийн төсөл (хөнгөлөлттэй зээл)

Уг төслийн зорилго нь Монгол улс дахь жижиг дунд үйлдвэрүүдэд урт хугацааны зээл олгохын сацуу, санхүүгийн зуучлалын байгууллага болон жижиг дунд үйлдвэрийн чадавхийг сайжруулж, хувийн хэвшлийн салбарыг хөгжүүлэх, байгаль орчныг бохирдуулдаг бодисыг бууруулах зэрэг байгаль орчинтой холбоотой үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оршино.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог сайжруулах, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлсэн бусад тусламжууд

Япон улс нь “Татварын удирдлагыг бэхжүүлэх төсөл” (техникийн хамтын ажиллагаа) тэргүүтэй төслүүдээр дамжуулан татвар төвлөрүүлэлтийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох, татвар төлөгчид үзүүлэх үйлчилгээг сайжруулах ажилд 10 гаруй жилийн турш тусламж үзүүлсээр ирсэн. Мөн эрх зүйн тогтолцоог сайжруулах салбарын хувьд 2004 оноос хойш мэргэжилтэн урьж ажиллуулах, сургалтанд хамруулах зэргээр өмгөөлөгчийн системийг боловсронгуй болгож байна. “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлгийн хөтөлбөр” (буцалтгүй тусламж)-ийн хувьд Японы их сургуулиудын магистр, докторын сургалтанд 2001-2008 оны хооронд 139 шилдэг залуу оюутнуудыг суралцуулан, өндөр төвшний мэргэжил эзэмшүүлж байна.

(б) Орон нутгийн хөгжилд үзүүлэх дэмжлэг

Газар тариалан хөдөө аж ахуйг хослон эрхлэх загвар бий болгоход үзүүлэх тусламж (техникийн хамтын ажиллагаа)

2006 оноос эхлэн гурван аймгийн найман сумын 24 орон нутагт үйлдвэрлэлээс худалдаанд гаргах хүртэлх үйл явцад үндэслэн газар тариалан мал аж ахуйг хослуулж, харилцан ашиг шимийг хүртэх хөдөө аж ахуйн нэгдсэн загварыг бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлж байна. Цаашид шилдэг загварыг Монгол улс даяар нэвтрүүлснээр эрс тэс уур амьсгалаас үүдэлтэй эрсдлийг бууруулж, хөдөө аж ахуй эрхлэгчдийн орлогыг тогтворжуулан, улмаар хөдөө орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.



Сүүний чиглэлийн өндөр чанартай үүлдрийг нэвтрүүлэв.

“Өвсний үндэс” хөтөлбөр

“Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргаа, эмнэлэг, бага сургууль зэрэг ашгийн бус байгууллагуудын хөгжилд хувь нэмэр оруулах төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж байна. Жилд ойролцоогоор 20-30 төсөл хэрэгжүүлж байгаа ба үүний 80 орчим хувь нь хөдөө орон нутагт хэрэгждэг. Ихэнхдээ цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгын засвар, дотуур байрны засвар болон барилга барих, эмнэлгийн барилгын засвар болон өргөтгөл хийх, мөн худгийн засвар голчилсон усан хангамжийг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлж байна. 2007 оны санхүүгийн жилд 23 төсөл хэрэгжүүлснээс 20 нь хөдөө орон нутгийн хөгжлийг тэтгэх төслүүд байлаа. (10-р хуудасыг үзнэ үү)



Улаанбаатар хотын Гэмтэл согог судлалын үндэсний төвд түргэний машин тээвэрлэх төсөл

Тухайлбал:

- Орхон аймгийн Нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн холбоо, нөөцийн цахилгаан үүсгүүрийн систем нэвтрүүлэх төсөл (2005 оны санхүүгийн жил)
- Төв аймгийн Мөнгөнморьт сумын усан хангамжийг сайжруулах төсөл (2005 оны санхүүгийн жил)
- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 11 жилийн сургуулийн дотуур байрны барилга барих төсөл (2006 оны санхүүгийн жил)
- Улаанбаатар хотын Баянгол дүүргийн албан бус сургалтын төвийн барилга барих төсөл (2007 оны санхүүгийн жил)
- Дорнод аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын 11-р сургуулийн ариун цэврийн байгууламжийн барилга барих төсөл (2008 оны санхүүгийн жил)
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1-р цэцэрлэгийн барилгын их засварын төсөл (2008 оны санхүүгийн жил)

Хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих хамтын ажиллагааны бусад жишээ

Японы засгийн газар нь Монголд үйл ажиллагаа явуулж буй Японы төрийн бус байгууллагыг дэмжих зорилготой “Япон улсын засгийн газраас Японы төрийн бус байгууллагатай хамтрах буцалтгүй тусламж”-ийн хүрээнд хөдөө орон нутгийн боловсрол, эмнэлгийн салбарын үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна.

(в) Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж

Ус намгархаг газрын экосистемийг хамгаалах, зохистой ашиглах, голын сав газрын менежментийн загвар төсөл (техникийн хамтын ажиллагаа)

Өнөөгийн байдлаар Монгол улсын хэмжээнд Рамсарын конвенц (усны шувуудын нутагладаг газар гэдгээрээ олон улсын хэмжээнд ач холбогдолтой ус намгархаг газартай холбоо-той конвенц)-ид 11 бүс бүртгэгдсэн байдаг. Харамсалтай нь өнөөдөр Монголд Рамсарын конвенцид бүртгэлтэй бүсүүдийн экосистемийг хамгаалах талаар ямар нэг үр дүнтэй арга хэмжээ авагдахгүй байна. Иймээс “Ус намгархаг газрын экосистемийг хамгаалах, зохистой ашиглах, голын сав газрын менежментийн загвар төсөл”-ийг Өгий нууранд хэрэгжүүлж, тухайн бүс нутгийн онцлогт тохирсон хэлбэрээр байгаль орчныг хамгаалах, нөөцийг нь зохистойгоор үргэлжлүүлэн ашиглахыг зорьж байна.

Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл (хөгжлийн судалгаа, буцалтгүй тусламж)

“Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн судалгаа”-г 2004 оноос эхлэн 3 жилийн хугацаанд явуулсан ба 2020 он гэхэд хог хаягдлын менежментийг зохицуулах чадвартай болгох зорилгоор “Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө”-г боловсруулсан. Япон улс нь уг мастер төлөвлөгөөнд үндэслэн Улаанбаатар хотын баруун хойд хэсэг (хуучин хогийн цэгээс баруун хойш 1 км)-т орших Нарангийн энгэрт тохиромжтой хувилбараар хог хаягдлыг эцэслэн хуримтлуулах цэг барьснаас гадна хогны машин зэрэг тоног төхөөрөмжийг нийлүүлэх зорилготой “Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлсэн. Үүнд шаардагдах хөрөнгө болох ойролцоогоор нэг тэрбум иенийг буцалтгүй тусламжаар олгосон байна.



Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл

(г) Эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийг буй болгоход үзүүлэх тусламж

Улаанбаатар хотын хот байгуулалтыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний шинэчлэлт

Монгол улсын нийт хүн амын тэн хагас нь оршин суудаг нийслэл Улаанбаатар хотын өмнө хүн амын хэт өсөлт, гэр хорооллын тэлэлт, агаарын бохирдол, газрын хувьчлалт ба ашиглалт зэрэг олон асуудал тулгарч байна. Нийслэлийн хот байгуулалтын мастер төлөвлөгөө нь 2002 онд анх батлагдсан авч өнөөгийн нийгмийн орчин нөхцөл тухайн үеийн байдлаас ихээхэн өөрчлөгдсөн тул мастер төлөвлөгөө өнөөгийн нөхцөл байдалд нийцэхгүй байгаа билээ. Иймээс Япон улсын засгийн газар 2007 оны 3 дугаар сараас “Улаанбаатар хотын хот байгуулалтын мастер төлөвлөгөө, хот хөгжүүлэх хөтөлбөр” (хөгжлийн судалгаа)-ийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд, 2009 оны 3 дугаар сар гэхэд доорхи гурван хөтөлбөрийг боловсруулан гаргахаар төлөвлөж байна. Үүнд:

- (1) Улаанбаатар хотын хөгжлийн тодорхой хэтийн төлөв, стратеги
- (2) Нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх богино хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр
- (3) Богино болон дунд хугацааны хөгжлийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн хотын хөгжлийн хөтөлбөр

Улаанбаатар хотод олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл (хөнгөлөлттэй зээл)

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр үйлчилгээний салбар хөгжиж олон улсын нислэг голлосон нисэх онгоцны буудлын эрэлт хэрэгцээ огцом өссөн. Нөгөөтэйгүүр өдгөө үйл ажиллагаа явуулж байгаа Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал нь газарзүйн байдлаас шалтгаалан огцом өсөж буй хэрэгцээг хангаж чадахгүйд хүрээд байна. Далайд гарцгүй Монгол улсын хувьд олон улсын нисэх онгоцны шинэ буудал байгуулах нь эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд нэн шаардлагатай асуудал болоод байна. Энэ төслийн зорилго нь газарзүйн саадгүй газарт орчин үеийн технологиор хангасан нисэх онгоцны буудал барьж, агаарын тээвэрт хүлээлгэх итгэл болон нислэгийн аюулгүй байдлыг дээшлүүлэхэд оршино. Уг төсөлд Япон улсын технологи шилжүүлэн нэвтрүүлэхийг дэмжих зорилготой “эдийн засгийн түншлэлийн онцгой нөхцлүүд” (STEP)-ийг тусгасан бөгөөд, жилийн 0.2 хувийн зээлийн хүүтэйгээр (зөвлөх үйлчилгээний хувьд 0.01 хувь), 40 жилийн хугацаанд эргэн төлөх (эхний 10 жил нь үндсэн зээлээбуцаан төлөх шаардлагагүй ч зээлийн хүүгээ төлөх шаардлагатай) туйлын ашигтай нөхцлөөр энэхүү зээлийг олгож байгаа юм.

Тухайн салбар дахь хамтын ажиллагааны бусад

Япон улсаас Нарны замыг засварлах “Улаанбаатар хотын авто замыг сайжруулах төсөл” (буцалтгүй тусламж), Хэнтий аймгийн Өндөрхааны чиглэлийн замыг засварлах “Зүүн бүсийн гол замыг барих болон зам барилгын тоног төхөөрөмж сайжруулах төсөл”, “Төмөр замын тээвэрлэлтийг сайжруулах төсөл” (хөнгөлөлттэй зээл) зэргийг хэрэгжүүлэн, авто зам болон төмөр замын тээвэрлэлтийн салбарт тус тус тусламж үзүүлсэн. Мөн Монгол улсын хамгийн том цахилгаан станц болох дулааны 4-р цахилгаан станцад удаа дараалан буцалтгүй болон хөнгөлөлттэй зээлийн тусламж үзүүлсэнээс гадна Япон улсаас ахмад сайн дурын гишүүн урьж ажиллуулах зэрэг байгууллагын үйл ажиллагаа сайжруулахад чиглэсэн тусламжууд үргэлжилсээр байна. Харилцаа холбооны салбарт “Богино долгионы радио нэвтрүүлгийн сүлжээ сайжруулах төсөл” (буцалтгүй тусламж) болон “Цаг агаарын мэдээний сүлжээг боловсронгуй болгох төсөл” (буцалтгүй тусламж) зэрэг төслийг хэрэгжүүлснээс гадна Улаанбаатар хотын усан хангамжийг сайжруулах 2 удаагийн тусламж үзүүлэн Монгол улсын дэд бүтцийг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулж байна.

Олон улсын байгууллагаар дамжуулан Монгол улсад үзүүлэх тусламж

(а) Хүний аюулгүй байдлыг хангах сан

“Хүний аюулгүй байдлыг хангах” тухай ойлголтод хүний амьд явах үндсэн эрхэнд аюул занал учруулахуйц нөхцлүүдээс хамгаалахын тулд улс орны төдийгүй хувь хүний болон бүс нутгийн чадавхийг дээшлүүлэх замаар асуудлуудыг иж бүрнээр шийдвэрлэх асуудал багтдаг. Энэхүү үзэл санааг гадаад бодлогынхоо нэгэн чухал чиглэл хэмээн үздэг Япон улс нь олон улсын байгууллагаар дамжуулан хүний аюулгүй байдлыг хангах үүднээс 1999 оны 3-р сард НҮБ-ын дэргэд “Хүний аюулгүй байдлыг хангах сан”-г байгуулсан. Тус сангийн санхүүжилтэд 2008 он хүртэл 35,4 тэрбум иенийг Япон улсаас зарцуулсан байна. НҮБ-ын Хүүхдийн сан /UNICEF/, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /UNESCO/, НҮБ-ын Хүн амын сан /UNFPA/ зэрэг байгууллага нь тус сангийн дэмжлэгтэйгээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.



НҮБХАС “Нийслэл хотын ойролцоох бүс буюу зөвшөөрөлгүйгээр алт олборлогчдын нийгэм эдийн засгийн дорой байдлыг сайжруулах төсөл”

(б) Японы Итгэлцлийн сан

Япон улсын санхүүжилтээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын дэргэд байгуулагдсан Японы итгэлцлийн сан нь Дэлхийн банкны хөгжлийн бодлого, хүний нөөцийн хөгжлийн сан /PHRD/ болон Японы нийгмийн хөгжлийн сан /JSDF/, Азийн хөгжлийн банкны Японы тусгай сан /JSF/, Ядуурлыг бууруулах Японы сан /JFPR/-гаар дамжих 120 гаруй төслийг санхүүжүүлж, нийт 14 тэрбум гаруй иений мөнгөн тусламж үзүүлсэн байна. Одоогийн байдлаар Дэлхийн банкны “Мэдээлэл харилцааны дэд бүтцийг, сайжруулах төсөл”, АХБ-ны “Улаанбаатар хотын нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл” нь Итгэлцлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байна.



Дэлхийн Банкны “Тогтвортой амьжиргаа төсөл”-ийн хүрээнд малчин айлд худаг гаргаж буй нь

Хандивлагч орнуудын хамтын ажиллагаан дахь Япон Улсын гүйцэтгэх үүрэг

(а) Монгол Улсын Засгийн газар болон Хандивлагч орнуудын техникийн хамтын ажиллагааны уулзалт

2003 оны 11-р сард Токио хотноо зохиогдсон хандивлагч орнуудын 10 дахь удаагийн зөвлөлдөх чуулга уулзалтын дараа 11 дэх чуулганыг нь Улаанбаатар хотод хийгдэхээр төлөвлөгдөж байсан. Тус уулзалтын үеэр хандивлагчдын зүгээс Монгол улсад үзүүлэх тусламжийн дүнг олон нийтэд зарлахгүй боловч тогтмол үзүүлэх тусламжийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс нээлттэй хэлэлцүүлэг явуулахаар тусгасан байна. Ийнхүү 2006 оны 2-р сард Монгол улсын Засгийн газар болон хандивлагч орнуудын техникийн хамтын ажиллагааны анхдугаар уулзалт нь Монгол Улсын Засгийн Газар, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсанаас хойш 2006 оны 10-р сард 2 дахь, 2007 оны 4-р сард 3 дахь, 2008 оны 1-р сард 4 дэх уулзалтууд тус тус зохион явагдсан байна. Япон улс нь энэхүү уулзалтыг зохион байгуулах ажлыг дэмжихийн хамт идэвхтэйгээр оролцож байгаа билээ.

(б) Боловсролын салбар болон хот байгуулалтын салбарын уулзалт

Япон улс нь “Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөр”-ийн нэн салшгүй хэсэг болох хүний нөөцийн хөгжилд боловсролын салбарын гүйцэтгэх үүргийг өндрөөр үнэлдэг ба “Боловсролын салбар дахь зөвлөлдөх уулзалт”-ыг Япон улс нь Азийн хөгжлийн банктай хамтран удирдаж байна. Уг уулзалт нь Монгол улсын засгийн газар (Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам) болон боловсролын салбарын хандивлагчид хамтран Монгол улсад үзүүлэх тусламжтай холбоотой олон төрлийн асуудлыг хамтран хэлэлцэхэд чиглэсэн. Мөн “Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөр”-ийн хөгжлийн асуудлын нэг болох “Улаанбаатар хотын дэд бүтэц, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг “Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө, Улаанбаатар хотын хөгжлийн хөтөлбөрийн судалгаа”-тэй уялдуулахын зэрэгцээ нийслэл хот, томоохон суурин газрын өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн уулзалтыг ХБНГУ-тай хамтран удирдаж, Монгол улсын засгийн газар (Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам) болон хот байгуулалтын салбарын хандивлагчидтай нягт ажиллаж байна.

Соёлын салбар дахь хамтын ажиллагаа

Япон улс нь зөвхөн эдийн засагт төдийгүй соёлын салбарт анхаарлаа хандуулан улс орны бүтээн байгуулалтад тэмүүлэх улс орнуудын хүчин чармайлтыг дэмжих замаар хоёр орны хоорондын харилцан ойлголцол, найрсаг харилцааг гүнзгийрүүлэх үүднээс ХАЁТ-ийн хүрээнд соёлын салбар дахь буцалтгүй тусламжийг үзүүлж эхэлсэн билээ.

(а) Соёлын ерөнхий буцалтгүй тусламж

Соёлын ерөнхий буцалтгүй тусламж нь соёл, дээд боловсролыг хөгжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга байгууламж засварлахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр хангадаг тусламж юм. Монголд 2007 оны санхүүгийн жил хүртэл 19 төсөл, нийт 1 тэрбум 50 сая 800 мянган иений тусламжийг үзүүлсэн. Өнөөг хүртэл Монгол Улсын Их Сургуульд лингафоны тоног төхөөрөмж, хэвлэлийн тоног төхөөрөмж (1984 он, 2000 он), Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт гэрэлтүүлэг, дуу авианы тоног төхөөрөмж (1994 он), Монголын үндэсний телевиз (одоогийн Монголын Үндэсний олон нийтийн телевиз)-д телевизийн нэвтрүүлэг (2002 он), Улсын драмын академик театрт гэрэлтүүлэг, дуу авианы тоног төхөөрөмж (2003 он), Монголын хөгжим бүжгийн коллежид хөгжмийн зэмсэг (2005 он), Монголын байгалийн түүхийн музейд үзмэр болон дуу, дүрс бичлэгийн техник хэрэгслийг (2007 он) тус тус олгосон байна.



Монголын Хөгжим Бүжгийн Коллежийн хөгжмийн зэмсгийг сайжруулах төсөл: Хүлээлгэн өгөх ёслолын ажиллагааны концерт

(б) Соёлын ерөнхий буцалтгүй тусламж

“Соёлын Өвсний үндэс” буцалтгүй тусламж нь орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага зэрэг хөгжиж буй орны ард иргэдийн түвшинд шууд тусламж үзүүлэх замаар ард түмний хэрэгцээнд илүү нийцсэн тусламж үзүүлэхийг зорьж буй. Монголд 2007 оны санхүүгийн жил хүртэл нийт 235,863 ам долларын өртөг бүхий 4-н төсөл хэрэгжүүлсэн бөгөөд 2005 онд Соёлын Төв Өргөө Цогцолборын дуу авианы тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл, 2006 онд Хэнтий аймгийн “Аврагын балгас”-ыг хамгаалах хашаа барих төсөл, 2007 онд Соёл-Эрдэм Дээд сургуулийн Япон хэлний сургалтын тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл, Монголын хүүхдийн ордны гэрэлтүүлэг болон дуу авианы тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлсэн юм.



Япон улсаас Монгол улсад суугаа Элчин Сайдын Яамнаас Япон дууны наадмыг соёлын төв өргөөнд зохион байгуулж буй

(в) НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаар дамжсан хамтын ажиллагаа

Япон улс нь НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаар дамжуулан хөгжиж буй орны соёлын өв сан болон уламжлалт соёлыг хадгалах, соёлын арга хэмжээг идэвхтэйгээр туслан дэмжиж байна. Монголд үзүүлсэн тусламжийн хувьд НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага дахь соёлын өв санг хадгалах Японы Итгэлцлийн сангаар дамжуулан 1995 оноос 1998 онуудад Хар Хорины туурийн газрын зургийг бүтээн, туурь болон түүний ойр орчмын газрын судалгаа явуулсан ба НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын биет бус соёлын өвийг хадгалах, хөгжүүлэх Японы Итгэлцлийн сангаар дамжуулан 1999 оноос 2000 онуудад Монгол ардын аман зохиолыг хальсанд буулгаж, 2004 оноос 2007 онуудад үндэсний уламжлалт морин хуур хөгжмийг хадгалж хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулсан байна.

[illegible]

=Ерөнхий боловсрол

=Сургуулийн өмнөх боловсрол

Хүдгийн шинэчлэл

Эрүүл мэнд

=Байгаль орчин

=Нийт хэрэгжсэн төслийн тоо

Япон улсаас Монгол улсад үзүүлсэн ХАЁТ-ын үзүүлэлтүүд

Буцалтгүй тусламж

/зуун сая иенээр/

Санхүүгийн жил	Дүн
2001	55.12
2002	40.60
2003	30.85
2004	18.80
2005	40.06
2006	43.30
2007	41.34
Нийт дүн	831.60

Техникийн хамтын ажиллагаа

Санхүүгийн жил	Дадлагажигчийн сургалт	Мэргэжилтний томилгоо	Судлагааны багийн томилгоо
2001	266	128	197
2002	325	82	153
2003	300	48	122
2004	397	74	172
2005	158	55	57
2006	256	113	64
2007	345	109	100
Нийт дүн	2302	821	2578

Техникийн хамтын ажиллагаа Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт

/сая иенээр/

Санхүүгийн жил	Дүн
2001	211.59
2002	128.28
2003	64.6
2004	108.26
2005	71.83
2006	132.03
2007	225.89
Нийт дүн	2574.82

Хөнгөлөлттэй зээл (1991-2007) /зуун сая иенээр/

	Төслийн нэр	Он	Дүн
1	Барааны зээл (1)	1991	48.36
2	Барааны зээл (2)	1992	24.59
3	Төмөр замын тээвэрлэлтийг сайжруулах төсөл (1)	1993	33.21
4	Төмөр замын тээвэрлэлтийг сайжруулах төсөл (2)	1994	47.53
5	Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцын засварын төсөл (1)	1995	44.93
6	Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг хөгжүүлэх төсөл (1)	1996	58.27
7	Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг хөгжүүлэх төсөл (2)	1997	42.98
8	Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцын засварын төсөл (2)	2000	61.39
9	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчинг хамгаалах 2 үе шаттай зээл	2005	29.81
10	Улаанбаатар хотод олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл	2007	288.07
Нийт дүн			679.14

Хүснэгт 1

Хандивлагч орнуудын Монголд үзүүлсэн тусламжийн тоо

Эх сурвалж: ХТН

/сая доллар/

Он	2002	2003	2004	2005	2006
1-р байр	Япон	Япон	Япон	Япон	Япон
	79.01	67.27	65.57	56.48	46.92
2-р байр	Герман	Герман	Герман	Герман	Герман
	23.19	29.94	26.54	28.17	29.73
3-р байр	АНУ	АНУ	АНУ	АНУ	Итали
	20.43	16.08	25.90	18.14	14.00
4-р байр	Норвеги	Швед	Голланд	Голланд	АНУ
	2.64	10.61	9.51	7.49	12.42
5-р байр	Голланд	Испани	Англи	Франц	Голланд
	2.55	6.52	7.37	6.79	8.02
Бусад	13.47	17.57	19.53	14.8	15.53
Нийт дүн	141.29	147.99	154.42	131.87	126.62

Хүснэгт 2

Олон улсын байгууллагуудын Монголд үзүүлсэн тусламж

Эх сурвалж: ХТН

/сая доллар/

Он	2002	2003	2004	2005	2006
1-р байр	АХБ	АХБ	ОУХН	АХБ	АХБ
	26.13	38.50	47.19	25.82	23.35
2-р байр	ОУХН	ОУХН	АХБ	ОУХН	ОУХН
	13.26	27.88	36.98	12.06	11.48
3-р байр	ЕХН	ОУВС	ЕХН	ЕХН	ЕХН
	3.08	2.85	4.04	6.36	3.11
4-р байр	НҮБТТХ	ЕХН	НҮБТТХ	ЕСБХБ	ХАХОУС
	3.02	2.74	2.74	3.45	3.44
5-р байр	НҮБХАС	-	НҮБТТХ	НҮБТТХ	ХАХОУС
	1.99	-	2.29	3.2	2.08
Бусад	-2.72	11.91	1.73	3.1	3.8
Нийт дүн	44.76	86.62	95.68	53.98	46.20

**Эдийн засгийн хамтын ажиллагаатай холбоотой материалыг
доорх хаягаар авна уу**

Япон улсын ГХЯ (ХАЁТ-ийн вэб сайт)

<http://www.mofa.go.jp/mofaj/gaiko/ODA/index.html>

Монгол улсад суугаа Японы Элчин сайдын яам

http://www.mn.emb-japan.go.jp/index_j.htm

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага

<http://www.jica.go.jp/Index-j.html>

(Энэхүү товхимолыг хамтран бэлтгэсэн:

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (ЖАЙКА) Монгол дахь
төлөөлөгчийн газар)



**Япон улсаас Монгол улсад
суугаа Элчин сайдын яам**

Хаяг: Сүхбаатар дүүрэг

Олимпийн гудамж

Ш.Х 1011

Улаанбаатар, Монгол

Утас: 11-320777

Факс: 11-313332

Цахим шуудан: jpemb@mongol.net

Вэб сайт: <http://www.mn.emb-japan.go.jp>